



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

19 97 оны 7 дугаар
сарын 3 өдөр

Дугаар А/120

Улаанбаатар
хот

Түүхий эдийн зах ажиллуулах
тухай

1. Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, "Худалдааны техник" ХКомпаний хүсэлтийн дагуу Баянгол дүүргийн Ү хорооны нутаг дэвсгэрт түүхий эдийн "Баянгол" зах байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Захын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн ажлын албаны Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс (н.Болд), Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Орон нутгийн үйлчилгээний хэлтэс (н.Баяр) нарт даалгасугай.
3. Захын байр, талбайн ариун цэвэр, тохижилт соёлжилтийг хэвийн байлгах байгаль орчныг бохирдуулахгүй, оновчтой зохион байгуулан зохих журмын дагуу ажиллуулахыг "Худалдааны техник" ХКомпани (н.Мэндсайхан)-д үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ж.НАРАНЦАЦРАЛТ